

ХУТАГТ ХУВИЛГААДЫГ ТОДРУУЛДАГ БУДДЫН ЁСНЫ ТУХАЙД¹

М.Гантуяа (Prof)

МУИС. ИИШУС.

Шашин Судлалын Тэнхим

Түлхүүр үг: хойд нас, дахин төрөл, хувилгаан төрөл, үйл үр, хутагт хувилгаад, хэлмэгдэл, цагаатгал, хувилгаан дүр тодруулах, сүсэг бишрэл, эх оронч үзэл

Товч утга: Энэхүү өгүүлэлд бурхан шашинд сургадаг үйл үр, хойд нас, дахин төрөл, бодьсадвын хувилгаан дүр гэх мэт ойлголтууд нь Энэтхэг, Төвд, Монгол газраа уламжлан намлогдсоны үр дүнд бурханы шашныг дэлгэрүүлэн хөгжүүлэх үйлст бодьсадвын хувилгаан төрлүүд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг гэсэн итгэл үнэмшлийн үүднээс Монголд төрсөн олон хутагт хувилгаадын үйл хэрэг, заяа төөрөг хэрхэн буурсан болон дахин сэргэж байгаа түүхэн тоймыг гаргахыг зорьлоо.

Хүн гэдэг бол бие, сэтгэлийн цогц мөн бөгөөд хүн үхэхэд бие нь ч, сэтгэл (сүнс) ч үгүй болно, гагцхүү үйл нь дараагийн өөр бие, сэтгэлийн цогцод эргэн төрнө гэж Буддын сургаалд номлодог. Гэвч хүмүүс өөрийн энэ бие, сэтгэлийн аминчхан хэрэгцээндээ захирагдан төөрөгдсөн байдаг тул үхсний хойно үйлийн мунхаг л үлдэнэ. Тэрхүү мунхаг үйл санамсаргүй тааралдсан аль нэгэн биед дараагийн төрлөө олж төрдөг гэнэ. Харин Буддын бясалгалын аргаар бие, сэтгэлээ тайвшруулж мунхагаас ангижран амгалангийн дээдэд хүрвэл өнгөрсөн төрлөө эргэн санаж буяны үйлээ тасралтгүй үргэлжлүүлэх боломжийг олдог ажээ.

Төвд, Монголд өргөн дэлгэрсэн Буддизмын хөгжлийн дээд шат болох Очирт хөлгөний ёсонд сүм хийдийн нарийн дэг сургуулиар хүмүүжсэн хувраг хүн Буддын шашин-соёлыг уламжлуулан хөгжүүлэх цорын ганц зорилгод бие сэтгэлээ зориулвал түүний үйл хэрэг төрөл дамжин хутагтуудын буяны үйлээр тасралтгүй үргэлжлэнэ. Буддизмд “эргэн төрөх” гэсэн ойлголт нь “сүнс” гэсэн утга илэрхийлдэг бус, харин “үйл” гэсэн утгаар хэрэглэгддэг болохыг энд цохон тэмдэглэе.

Тухайлбал, XVI зуунд Төвдөд үүссэн Гелүмба (шарын шашны) ёсыг үндэслэгч Богд Зонхавын гутгаар дүр Содномжамц багшид Түмдийн Алтан ханаас өргөсөн “Далай лам” нэрээр энэ шашны тэргүүний 14 хойд дүр эдүгээг хүртэл үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлж байна. Мөн Монголын шарын шашны тэргүүн анхдугаар Богд өндөр гэгээн Занабазарын хувилгаан дүрийг тодруулсаар эдүгээ аравдугаар Богд Монголын шарын шашныг тэргүүлэх үйл хэргийг залгамжлан явуулж байх учиртай. Энэ мэтчилэн Монголын орон газар бүхэн дор бүрдээ шашны хэргийг эрхлэх хутагт хувилгаадыг тодруулж ирсэн түүхтэй. Хутагт хувилгаан тодруулна гэдэг нь Буддын шашин-соёлыг тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн гол зорилгыг агуулж байдаг. Иймээс аль нэг хувилгааныг тодруулах нь тухайн “бие хүнийг” онцгойлж байгаа хэрэг бус, Буддын шашин-соёлыг тухайн орон газар, ард түмний дотор уламжлан хадгалж,

1. Өгүүлэг “Монголын ард түмнүүдийн нийгэм-соёл, улс төрийн бодит байдал: уламжлал ба орчин үе” сэдэвт хамтын ажиллагааны судалгааны хүрээнд бичигдэв. Эта статья написана под проектом «Буддизм в социокультурных и политических реалиях монгольских народов: традиции и современность»

дэлгэрүүлэн хөгжүүлж байгаа буяны үйл хэрэг болно. Гэвч түүхэнд энэхүү үйл ажиллагааг улс төрийн ашиг сонирхолд нийцүүлэх гэсэн оролдлого давамгайлж, гунигтай үр дүнд хүргэсэн нь олон. Монголын эзэнт гүрний үед шашныг хэзээ ч төрийн хэмжээнд өргөмжилж байгаагүй боловч шашныг үргэлж хүндэтгэн дээдэлж ирснийг санууштай.

Хутагт хувилгаадыг тодруулахдаа өмнөх төрлийг нь сануулах аргыг гол шалгуур болгодог. Орчин үеийн өрнийн психологичдоос хүмүүсийн ой санамж, зүүд зөн зэргийг судлах явцад зарим судалгаанд хамрагдагсад энэ насандаа үзээгүй, тохиолдоогүй газар орон, зүг чиг, хүмүүс үйлдлүүдийг бодитоор нь нэрлэн заасан тохиолдлууд цөөнгүй бүртгэгдсэн хэдий ч “эргэж төрдөг” тухай шинжлэх ухааны баттай нотолгоо гараагүй гэдгийг энд дурдъя.

Монгол нутаг бол номч мэргэн, эрдэм төгс хутагтуудын эргэн эргэн төрдөг эх орон, өлгий нутаг нь билээ. Эрдэм мэдлэг, ид чадал, буянт үйлээрээ Монгол сүсэгтэн олны хайр хүндэтгэлийг хүлээсэн үй олон хутагт хувилгаад Монгол газраас төрөн гарсан бөгөөд тэдний байгуулсан сүм хийдийн хурал номын бүтээлийг дэлгэрүүлэн хөгжүүлэх зорилгоор Монголчууд жилээс жилд өргөл мөргөл үйлдэж, буян хишгээ өргөж, мал ахуйгаа хандивлаж, шавь ардын үйлийг үүсгэж ирсэн бөгөөд хутагтуудын шавь нарын тоо нь он жил ирэх тутам олширч тэдний мал сүрэг нь хошуу нутагтаа багтахгүй болсноор манжийн төрөөс шавь нар захирах “тамга” (эрх) олгодог болжээ. XX зууны эх гэхэд Манжийн хаанаас батламжилсан тамга бүхий 13 тамгатай хутагт шашин, нийгэм, соёлын өргөн хүрээний үйл ажиллагаа явуулж, онцгой эрдэм чадлаараа сүсэгтэн олны гайхшрал, бишрэлийг төрүүлж байжээ. Тэдгээрийг дурдвал:

1. Халхын шарын шашны тэргүүн VIII Богд Жавзандамба хутагт

2. Засагт хан аймгийн Жалханз хутагт

3. Засагт хан аймгийн Ялгуусан хутагт

4. Засант хан аймгийн Бигэрийн Номун хутагт

5. Цэцэн хан аймгийн Егүзэр хутагт

6. Цэцэн хан аймгийн Ялгуусан хутагт

7. Сайн ноён хан аймгийн Ламын гэгээн Эрдэнэ бандид хутагт

8. Сайн ноён хан аймгийн Чин сүжигт Номун хан хутагт

9. Сайн ноён хан аймгийн Зая бандид хутагт

10. Сайн ноён Нар Ванчин хутагт

11. Сайн ноён хан аймгийн Эрдэнэ мэргэн ноён хутагт

12. Сайн ноён хан аймгийн Шивээ ширээт хутагт

13. Сайн ноён хан аймгийн Хамба хутагт – эдгээр болно.

Одоо тэдний хувилгаан дүрийг тодруулсан түүхээс заримыг дурдъя.

Өндөр гэгээн Занабазар хэмээн алдаршсан Монголын шарын шашны тэргүүн Анхдугаар Богд Жэвзундамба хутагт Лувсандамбийжанцан (1635-1723) Түшээт хан аймгийн Илдэн бэйлийн хошууны нутаг Усан зүйл хэмээх газар, одоогийн Өвөрхангай аймгийн Зүйл сумын нутагт 1635 оны модон гахай жил Түшээт хан Гомбодорж, хатан Ханджамц нарын гэрт мэндэлжээ. Гурван сүүдэртэйдээ Манзушри бурханы магтаал Жамбалцанжод номыг цээжээр унших, 4 настайдаа Энэтхэг, Төвд хэлээр зарлиг зохиолыг унших зэрэг сонин гайхамшигийг үзүүлж, Жамбалин номун хаанаас увш санваар, енса брүлгү Лувсанданзанжамцаас равжун сахил хүртэж Лувсандамбийжалцан хэмээх алдартай болжээ. Төвдийн V Далай лам Агваанлуvsанжамц, Банчин Богд Лувсанчойжижанцан, Найчун чойжин нар Жэвзүн Дарнатын хувилгаан мөн болохыг тодруулж таван сүүдэртэйд нь Их Монгол уулын энгэрт байх Ширээт цагаан нуурын дэнжид Монголын шашны тэргүүн анхдугаар Богдоор өргөмжлөн ширээнд залжээ. Гэгээний арван гурван сүүдэртэйд нь Түшээт хан Гомбодорж, Шолой сэцэн хан

нар Их Монгол уулын энгэрт үргэлжид суух сүм барьж өгсөн нь хожмоо Баруун хүрээ гэж алдаршжээ. Арван таван сүүдэртэйдээ 1649 онд Төвдэд хүрч V Далай лам, Банчин Богд нараас судар тарни, гүн ухааны номлолуудыг хүртсэн байна. Төрөлх нутагтаа эргэж иртэд Хангай ханы Шивээтэд Бүтээлийн сүмийг, 1654 оны морин жилд Хэнтий нуруунд Их хүрээг, 1702 онд Зүүн хүрээг үүсгэн байгуулсан байна. Мөн Төвдийн Гандан, Сэра, Дашлхүмбэ зэрэг хийдэд лам явуулж шашны гүн ухаанд суралцуулж байжээ. Өндөр гэгээн 1686 онд Бүтээлийн сүмд заларч байхдаа Монгол, Энэтхэг, Төвд гурван улсын номын хэлийг тэмдэглэж болох Соёмбо үсэг зохиож Ганжуурыг Монгол хэлнээ орчуулах ажлыг эхэлсэн аж. Монгол орондоо “Жалтэ тэмбан” хэмээх Ганжуурыг залж өөрийн мутраар гурав дахин бичиж бүтээх, Данжуурын 225 ботийг залж олон шавь нарын хамт шинээр бичих, Хурлын уншлага, Найман мянгат, Тогтоолын хураангуй, Алтангэрэл, Банзрагч, Их бодь мөрийн зэрэг, Хангал зэрэг номын барыг сийлүүлж хэвлэлийн ерөөлийн үгийг бичжээ. Өндөр гэгээн “Маани бүтээхийн гүн арга”, “Жинлавцогзол”, “Пунцагтүсүм” зэрэг зуу гаруй номоос бүрдсэн нэг боть зохиол туурвиж, Очирдара бурхан, Ногоон Дарь эх, Язгуурын таван бурхан, Аюуш, Манал зэрэг бурхад олныг бүтээсэн нь эдүгээ Монголын соёлын хосгүй нандин өвд зүй ёсоор тооцогдож байна.

Хоёрдугаар Богд Жэвзүндамба хутагт (1724-1757) Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошууны нутаг Туул голын сав Өгөөмөр хэмээх газар, одоогийн Төв аймгийн Алтанбулаг сум\ эцэг Эфү чин ван Дондовдорж, эх Баярт нарын гэрт луу жилд сонин гайхамшгийг үзүүлэн мэндэлж, 1727 онд дөрвөн нас сүүдэртэйд нь Төвдийн Банчин Богд Лувсан-Иш бээр Халхын Богдын хоёрдугаар дүр мөн хэмээн тодруулж Лувсандамбийдонмэ хэмээх нэрийг хайрлажээ. 1729 онд зургаан нас сүүдэртэйд нь Саадаг хэмээх газарт Халхын хоёрдугаар Богдод өргөмжилж, Хөхнуурын Донхор хутагт Агваанжамбалданзанг ёнзин багшид шүтэж судар тарнийн номын рашаан цаглашгүйг хүртсэн байна. Хоёрдугаар Богд 1739 онд Их хүрээнд Жүд дацан, 1745 онд Дамдин янсангийн хурал, 1750 онд Манзушри ламын хийд, 1756 онд Их хүрээнд гүн ухаан судлах Дашчоймпэл дацанг байгуулж Гүнчин лам Жамъяншадвийдоржийн игчааг тогтоожээ.

Гутгаар Богд Жэвзүндамба хутагт Ишдамбийням (1758-1773) нь Төвдийн Литанд түшмэл Данзангомбо, эх Норжинбаммо нарын гэрт мэндэлж, IY Банчин-Эрдэнэ бээр Халхын Богд III Жэвзүндамба мөн хэмээн тодруулжээ. Тэрээр Жанжаа хутагт Ролбийдоржоос гэцэл санваар хүртэж номун хан Жамбалдоржийг ёнзин багшид шүтэж судар тарнийн номын рашаан хүртжээ. 1763 онд гуравдугаар Богдыг ширээнд нь залжээ. Богд гэгээн Их хүрээнд Винайн зуны их хайлан, 1760 онд Манба дацан, 1765 онд Дамбадаржаагийн хийдийг үндэслэн байгуулж, Сэлбэ, Бэлхийн бэлчир дэх мод чулуу, тоосго ваарыг номин эрдэнэ мэт өнгөлөн дээвэрлэж, хана туургыг нь өнгө зохицсон хээгээр чимж оройд нь алтан ганжир залсан “Шашныг бадруулагч” Дамбадаржаа хийд хэмээн хожим алдаршсан байна.

Дөтгөөр Жэвзүндамба хутагт (1775-1813) нь Төвдийн Лхасын нутаг Жидшодын гол хэмээх газар түшмэл Содномдаш, эх Янжинлхам нарын гэрт сонин гайхамшгийг үзүүлэн мэндэлж, VI Банчин-Эрдэнэ Балдан-Иш, Ламо Чойжин нар Халхын Богд Жэвзүндамбын дөрөвдүгээр дүр мөн хэмээн тодруулжээ. Тэрээр Банчин-Эрдэнээр үсэг уншлага заалган, VIII дүрийн Далай ламаас Жамбалжамц ЛувсанТөвдэнванчүгжигмэджамц алдрыг хүртжээ. Брайвүн Гомон гэвш Лхарамба Агваанпринлэйг ёнзин багшид шүтэж судар тарнийн номын рашааныг хүртжээ. Долоон сүүдэртэйд нь 1781 онд Их хүрээнд залж Халхын Богд Жэвзүндамбад өргөмжлөв. Тэрээр одоогийн Гандантэгчэнлин хийд байгаа газарт Далх бурханы тахилгыг уншин сан тавин ариулж, сүмийн шав тавьж равнай өргөөд Зүүн хүрээнээс чойрын хоёр дацанг нүүлгэж ирсэн байна. Мөн Их хүрээнд 1789 онд Зурхайн дацанг, 1806 онд нууц тарнийн ёсны Дүйнхор дацанг, 1807 онд бясалгал дияаны Шадүвлин хийдийг, 1809 онд Төвдийн гүн ухаантан Банчин Содномдагвын игчааны дагуу Гунгаачойлин дацанг тус тус байгуулж Монгол оронд судар тарнийн ёс хөгжихөд ихээхэн хувь нэмэр оруулсан байна.

Тавдугаар Богд Жэвзүндамба хутагт (1815-1841) нь Төвдийн Лхасын ойролцоо Зан мужийн Гэдинхансор хэмээх газар түшмэл Гомбодондов, эх Рингэнбүтэд нарын гэрт ХIY жарны хөхөгчин гахай жилийн зуны дунд сарын шинийн долоонд онцгой шинж тэмдгийг үзүүлэн мэндэлсэнийг долдугаар Банчин-ЭрдэнэДамбийням бээр Халхын V Богд мөн хэмээн тодруулж Лувсанчүлтэмжигмэдламбийжанцан хэмээх алдрыг хайрлажээ. 1820 оны намрын дунд сарын 16-нд Богдын зургаан нас сүүдэртэйд ширээнд залж, Лосалингэвш Жүдмадба Лувсанжамъянгийн ёнзин багшид шүтэж гэгцэл сахил хүртэн судар тарнийн номын рашааныг хязгаарлашгүй хүртжээ. Богд хорин сүүдэртэйдээ 1834 онд Их хүрээнд Монгол маягийн хэв загвартай Майдарын сүм баруулж, 80 тохой Майдар бурхан, Баруун Чойрт Алтан Ганжуур тус тус бүтээлгэн залж байжээ. Мөн 1837 онд Далхын дэнжид Гандантэгчэнлин хийдийг нүүлгэн ирүүлжээ. Y Богд Жэвзүндамбын үед 1841 онд Ламрим дацанг байгуулж, Их хүрээнд Зүүн хүрээнээс гадна гүн ухааны болон Ламрим, Бадма ёга дацангууд төвлөрч Гандан хүрээ гэж нэрлэгдэх болсон ба гүн ухаан судалдаг баруун дацанд Гунгаачойлин, зүүндацанд Дашчойингэл хэмээх нэрийг тус тус хайрласан байна. Тавдугаар Богдын ёнзин багш нь Лхаарамба Лувсанжамъян, Онгийн голын Брагри ёнзин Дамцагдорж нар байв. Өөрийн ёнзин багш Брагри Дамцагдоржоос Нарохажид бурханы авшиг удисыг хүртэж, бясалгал бүтээлийг хийж өвлийн адаг сарыг 25-нд Их хүрээнд жинсрэг цутгаснаар үдэш нь дөрвөн уулын хооронд улаан туяа татсаныг Нарохажид бурхан бодитой заларсаны шинж тэмдэг гэж хуучин хүрээний настан буурлууд ихээхэн бэлэгшээж ярьцгаадаг байсан аж. Тэгээд одоогийн удирдлагын академын байрны өмнөхөн талд Туул голын хөвөөнд Нарохажид сүмийг байгуулжээ. Y Богд Дагнан, Сэгнан хэмээх бясалгал дияан зүүд нойронд нь ургасныг зурсан, Гандан хийдийн өргөжин тэлж хөгжихийг бэлгэдэж харуулсан зураг Гандан хийдэд хадгалагдаж байсан гэдэг. Тавдугаар Богдын айлдсан бошго лүндэн Орчонгийн сав шимийн дуулал зэрэг зохиол бүтээл багтсан нэг боть байдаг ажээ.

Зургадугаар Богд Жэвзүндамба хутагт (1843-1848) нь Төвдийн Лхасын умартад ХIY жарны харагчин туулай жилийн хаврын эхэн сарын 25-нд эцэг Содномдаржаа, эх Лхамдолгор нарын гэрт онцгой шинжийг үзүүлэн мэндэлснийг YП Банчин-Эрдэнэ Дамбийням бээр Халхын Богдын VI дүр мөн хэмээн тодруулж увш сахил хүртээн ЛувсанТөвдэнчойжижанцан хэмээх алдрыг хайрлажээ. Түүнийг ХIY жарны шороон бичин жилийн 9-р сарын 7-нд зургаан сүүдэртэйд нь буюу 1848 онд Монголд залж Халхын Богд Жэвзүндамбын 6-р дүрд өргөмжилжээ. Зургаадугаар Богдын ёнзингоор Төвдийн Гандан хийдийн Тива хувилгаан ИшТөвдэнжамц ирж ажиллаж байжээ.

Долдугаар Богд Жэвзүндамба хутагт (1849-1868) нь 1850 онд Төвдийн нутаг Лхасын ойролцоо гүн Мягмар, эх Норовлхам нарын гэрт онцгой шинжийг үзүүлэн мэндэлснийг ХI Далай лам Хайдавжамц бээр Халхын долдугаар Богдын дүрд тодруулж, Разан хутагт Наваан-Ишчойжилжамцаас санваар хүртэж ном айлтгажээ. 1855 онд буюу ХIY жарны хөхөгчин туулай жил зургаан настайд нь Их хүрээнд залж, Халхын Богд Жэвзүндамбын долдугаар дүрд өргөмжлөн, ёнзин багшаар лхарамба Агваан-Одсэрийг ажиллуулав. Түүний арав гаруй насандаа айлдсан гүр дуулал нь Их хүрээний номын мэргэдийн дунд алдаршсан байдаг.

Наймдугаар Богд Жэвзүндамба хутагт Агваанлуvsанчойжинямданзанванчүг (1869-1924) нь Төвдийн Лхаст түшмэл Гончигцэрэн эх Ойдовдулам нарын дөрөвдүгээр хүү болон мэндэлж, ХII Далай лам Принлэйжамц, Банчин Богд Дамбийванчүг нар түүнийг Халхын YШ Богд хэмээн тодруулж равжун сахил хүртээн Агваанлуvsанчойжинямдан занванчүг хэмээх алдрыг хайрлажээ. Манж чин улсын хаан Бүрэн засагчийн үед Монголд залж 1874 онд буюу билгийн ХY жарны хөхөгчин гахай жилийн өвлийн тэргүүн сард Их хүрээнд Халхын наймдугаар Богдод өргөмжилжээ. Номын багшид ёнзин Ари брүлгү Хайдавданзанчойжиням, Их хүрээний хамба Номун хан Гачин Балданчойнбэл, мөн Их хүрээний хамба Номун хан ёнзин Лувсанхаймчиг нарыг залж судар тарнийн номын рашаан хязгааргүйг хүртээжээ. Богд гэгээн

1908 онд Гунгаачойлин дацанд гавжийн дамжаа барьж гавж мяндаг цолтой болсон бөгөөд 1910 онд Их хүрээнд буддын гүн ухаан судлах Сэра игчааны дагуу Идгаачойнгийн дацанг, 1912 онд Жанрайсиг дацанг байгуулжээ. Мөн 1910 онд ҮШ Богдын зарлигаар Их хүрээнд хүрээ барын Ганжуурыг бүрэн хэвлэж хэвлэлийн ерөөлийн үгийг бичиж байжээ. 1911 оны пагаагчин гахай жилд Монголчууд үндэсний тусгаар тогтнолоо зарлаж VIII Богдыг Монгол улсын шашин төрийг хослон баригч, хэмжээгүй эрхт хаанд өргөмжилж өвлийн дунд сарын шинийн есөн буюу аргын 1911 оны 12 дугаар сарын 16-нд тусгаар тогтносон Богд хаант Монгол улсыг байгуулсан юм. Тэрээр 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалыг удирдан манлайлж, Манжийн дарлалаас салгаж, тусгаар улс болгож чадсан, нийт Монголчуудын оюун ухааны их удирдагч хэмээгдэн шүтэгдэж байсан юм. ҮШ Богдын санаачлагаар Өндөр гэгээний зохиосон Соёмбо үсгийг 1911 онд төрийн тугдалбаанд хүндэтгэлтэйгээр оруулсан байна.

Есдүгээр Богд Жэвзүндамба хутагт нь XVI жарны харагчин бичин жил буюу 1932 онд Төвдийн Лхас хотын ойролцоо Томсиг гэдэг газар эцэг Лувсанжамбал, эх Янжинлхамын гэрт маш сонин гайхамшигтайгаар лагшин мэндэлснийг 4 настайд нь XIII Далай ламын тамга түшиж байсан Радэн ринбүүчи, Найчүн Чойжин нар Халх Монголын наймдугаар Богд Жэвзүндамбын хойд дүрийн хувилгаан мөн хэмээн тодруулжээ. IX Богд Жэвзүндамба хутагт нь 8 сүүдэртэйдээ Радэн ринбүүчи Төвдэнжамбал-Ишээс гэгцүл сахилог хүртэж Жамбалнамдолчойжижанцан хэмээх алдартай болжээ. Тэрээр 7-21 насандаа Брайвун Гоман дацанд шавилан сууж гэвш Агваанчойдан, Халхын гэвш Дашжамц, Буриадын дүлба хамба Түвдэнням тэргүүтэн лам нарыг “Үндсэн багш”-д шүтэж буддын гүн ухаанд суралцсан ажгуу. Хутагт бээр дээд дүрийнхээ хувилгаан Жонон Дарнатын хийдэд 21-29 насандаа тарнийн гүн ухааныг судалж, багш Дагцар Ринбүүчи тэргүүтэн олон мэргэдээс номын рашаан хүртэж, бясалгал бүтээл олныг зохиож, бас өөрийн олон шавь нарт дээдийн номын даган соёрхол, эш цаглашгүйг хайрласан ба дээд багш нараасаа номын увидас, авшиг олонтаа хүртэж, бясалгал бүтээлийг олонтаа зохиосон. Цагийн эрхээр IX Богд Жэвзүндамба хутагт 1961 онд БНЭУ-д дүрвэн гарч Даржаалин, Масури, Мадьяа Парадеш зэрэг газруудад оршин сууж байгаад Дээрхийн Гэгээнтэн XIV Далай ламын тааллаар 1991 онд Дармасала хотод морилон ирж суурьшсан байна. Түүнийг 1992 онд Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам бээр Халхын Жэвзүндамба хутагтын IX дүрийн хувилгаан мөн болохыг баталгаалжуулжээ. Түүнээс хойш Энэтхэг улсын Дармасала хот дахь Дагдан өргөөндөө зарларч байгаад 2010 оноос Монгол орноо зарларч лам хуврага, сүсэгтэн олон шавь нарынхаа хүсэл сэтгэлийг номын рашаанаар цэнгүүлсэн юм.

Монголын шашин номын үйл хэрэгт ихээхэн хувь нэмэр оруулсан өндөр гэгээний хувилгаан дүрүүдээс гадна олон монгол хутагт хувилгаад өөр өөрсдийн хошуу нутаг, монголын нийгэм-соёлын үйлсэд томоохон хувь нэмэр оруулж ирсэн билээ. Монгол оронд тодорсон том, жижиг 80 гаруй хутагтын дотор төрийн тамгатай 13 хутагт бий. Монголчууд хутагт хувилгаадаа өөрийн шашны дэг жаягийн дагуу тодруулж байсныг Манж нар хориглон төрийн бодлогоор тодруулах хууль гаргаж, тусгай тамга олгох болсон бөгөөд Монголын олон хутагт хувилгаадаас XX зууны эхэн гэхэд эрдэм ном, ид чадал, энэрэнгүй үйлсээрээ монгол түмнийхээ бишрэл хүндэтгэлийг хүлээж, Манжийн хааны батламж тамгыг өөрийн эрхгүй эзэмдсэн 13 хутагтын хувилгаан дүрүүд, ялангуяа сүүлчийн дүрийнх нь талаар энд товч дурсацгаая.

Тухайлбал,

Шашин, төрийн том зүтгэлтний алдар нэр, эрх ямбыг хүндэтгэсэн Засагт хан аймгийн Ялгуусан хутагтын дүр эртний Жагарын оронд XIV зууны үеэс үүсч, Төвд, Халх, Ар Монгол, Богд хаант Монгол Улсад үе улиран тодорсон 16 хувилгаан энэ алдрыг хүртэж байжээ. Эдгээрээс эхний тав нь Энэтхэгт, дараагийн тав нь Төвдэд, сүүлчийн зургаа нь Монгол газар шороон дээр тодорч гарсан байна. Ялгуусан хутагтын хувилгаадын дотроос Монгол нутагт тодорсон зургаан хувилгааны талаар дурдъя.

Ялгуусан хутагтын арваннэгдүгээр дүр буюу Ар халхад тодорсон анхдугаар Ялгуусан хутагт Тутандамбийням Манж чин улсын Эсэр засагчийн арваннэгдүгээр он буюу 1654 онд Халхын Засагт хан аймгийн Хошууч мэргэн бэйсийн хошуу, одоогийн Завхан аймгийн Цагаанхайрхан, Цагаанчулуут сумын нутагт засаг ноён Зодовынд төрж, уугуул усандаа шашныг үндэслэх гэгээн лам “Ялгуусан мэргэн бандида хутагт”-аар тодорч, “Пунцаг зуу” хэмээх сүм байгуулан 13 жил суусан байна.

Ялгуусан хутагтын арванхоёрдугаар дүр буюу Ар Монголд тодорсон хоёрдугаар дүр Лувсандамбийжанцан Найралт төвийн тэргүүн он буюу 1723 онд Түвшээт хан 1725 онд Сайн ноён хан аймагт тодорч Тэнгэрийг тэтгэсэний есдүгээр он буюу 1754 оныг хүртэл 31 жил суужээ.

Ялгуусан хутагтын арвангуравдугаар дүр буюу Ар Монголд тодорсон гурав дахь дүр Лувсандамбадаржаа Тэнгэрийг тэтгэсний 22 дугаар он буюу 1757 онд Засагт хан аймгийн Дархан бэйсийн хошууны нутаг, одоогийн Ховд аймгийн Цэцэг сумын нутагт Цэцгийн дүр хэмээн тодорч бурхан шашны номд сайтар боловсорч, Ховдын “Түгээмэл амаржуулагч” - Өөлдийн шар сүмд 18 жил хурал номын ажил эрхлэн суужээ. Лувсандамбадаржаа хутагт 1804, 1811, 1818 онд Бээжинд морилж Тэнгэрийн гэгээнээ бараалхан дээдсийн түмэн өлзий батдахын ерөөл айлтгаж, “Шинэлэхийн жасаанд” оролцон тухай бүрт шан хишиг хүртжээ. Хутагт 1811 онд Улиастайн ойролцоо Алдар, одоогийн Алдархаан сумын төвийн орчим, “Яруугийн хүрээ” хэмээх газар өөрийн хүчээр том сүм бариулж, дээдэст айлтган “Хол дахиныг тогтоогч сүм” гэсэн нэр хайрлажээ. Энэ гавъяаг манжийн хаан хөхивлэн ногоон хөшигт жууз тэргээр шагнажээ. Лувсандамбадаржаа их зүйл бүтээсэн эрдэмтэй хутагт байж Ялгуусан хутагтын сэнтийд хамгийн удаан хугацаагаар буюу 62 жил суусан байна.

Ялгуусан хутагтын арвандөрөвдүгээр дүр буюу Ар Монголд тодорсон Номч дүр гэж алдаршсан дөрөвдүгээр дүр Лувсансамдав нь Сайшаалт ерөөлтийн 25 дугаар онд буюу 1821 онд Халхын Сайн ноён хан аймгийн Далай гүний хошуу, одоогийн Архангай аймгийн Цахир, Тариат сумын зааг нутагт бэйл ноён Гончигжавын тодорч, Засагт хан аймгийн Хамба хутагтын шавийн нутагт орж байсан Туна голын эхэнд Агитын дэнж, одоогийн Завхан аймгийн Идэр сумын нутаг Цэцэрлэгийн дэнж орчимд залагдаж, олон тооны гэр сүмд суужээ. Лувсансамадав хутагт бурханы шашны номд түргэн боловсорч “Цанид номын сургууль” дүвргэсэн, номч хутагт гэгдэж “Сайнаар судлагч” буюу Санчувлин хийдэд олон жил сууж, 1841, 1842 онд Бээжинд явж Тэнгэрийн гэгээнд бараалхаж “Шинэлэхийн жасаанд”, 1852 онд “Түнелийн номын жасаанд” орж дээдсийн түмэн өлзий батдахын ерөөл айлтгаж тухай бүрийд хишиг шан хүртжээ. Дээдсийн зарлиг дагаж Ховдын “Түгээмэл амаржуулагч” сүмд зургаан жил сууж хурал номын ажил эрхэлжээ. 1836 онд Яруугийн хүрээнээс “Хол дахиныг тогтоогч” буюу “Дашпэлжээ данжиглан” сүмийг зөөж Идэрийн голын эхэнд газар шинжин Агитын дэнж гэж нэрлэсэн газраа уул сүмийг засч бариулан суусан нь хожим Хамбын шавийн хүрээ болон өргөжсөн аж. Мөн 1876 онд Цэцэрлэгийн дэнжид “Хол дахиныг тогтоогч сүм”-ийг шинээр бариулаад тэндээ насан хутаг олтол суусан байна. 1867 онд Засагт хан аймгийн харъяа Ялгуусан хутагтын шавь хошууг 150 эрийн үүрэг бүхий засаг захиргааны нэгж болгон байгуулаад шанзав засаг ламын тушаал, захирах тамга олгож хэрэг шийтгүүлснээр Лувсансамадав хутагт анхны тамгат Ялгуусан хутагтад өргөмжлөгдөж, нэвтэрхий сайн Самади гэгээний мөнгөн тамгыг залсан юм. Ингэснээр “Алтан мөнгөн тамгат Ар халхын Ялгуусан хутагт” гэж алдаршсан гэдэг. Лувсансамадав хутагт засаг төр, шашны үйл хэрэгт их гавьяа байгуулсны учир Манжийн хаанаас зарлигаар олгодог шагнал, алдар цолыг бүгдийг хүртэж, урт насалж, 1882 онд жанч халах хүртэл 61 жил Ялгуусан хутагтын сэнтийд суужээ. Түүний шарилыг “Дашлэлжээ данжиглан” хийдийн гүдэн дуганд зандалшуулж хадгалсан гэдэг.

Богд Ялгуусан хутагтын 15 дугаар дүр буюу Ар Монголд тодорсон тавдугаар дүр

Лувсанданзан халхын Засагт хан аймгийн Цогтой вангийн хошуу, одоогийн Завхан аймгийн Нөмрөг сумын засаг ноён, цогтой ван Загдсамбарын дорж, Манжийн тооллын Бадаргуулт төрийн 11 дүгээр он буюу 1885 онд тодрох үедээ насанд хүрсэн байсан тул хошуу шавийг захирах, хурал номын ажилд түвртэлгүй дасч, даруй даруйгаар дээдийн хишиг шагнал хүртэж ногоон хөшигт жуузаар шагнуулсан байна. Лувсанданзан хутагт, засаг лам Дамбий Осор нар өөрийн хийдэд Гүнрэгийн хурал, Гэсэрийн цамыг тогтоожээ. Тэрээр Ялгуусан хутагтын сэнтийд 27 жил сууж, тавь эргэм насандаа 1912 онд жанч халж гүдэн дуган гэгч тааллын шүтээнд оршсон байжээ.

Ялгуусан хутагтын 16 дугаар дүр буюу Ар Монголд тодорсон зургадугаар хувилгаан дүр **Чимидцэрэн** 1912 онд одоогийн Архангай аймгийн Цахир сумын нутаг - Халхын Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны ард Санжавын галд төрж, 1915 онд гурван настайд нь наймдугаар Богд бээр Ялгуусан хутагтын хувилгаан дүр мөн хэмээн тодруулж, Засагт хан, одоогийн Завхан аймгийн Идэр сумын нутаг дахь Ялгуусан хутагтын шавьд мөн оны намар залж, Санн ноён ханы аймгаас шунлайв багш Шагж, маарамба Самдан, сойвон Бүрнээ нар ирж, Тариатын хүрээнээс жүдийн хурлын ном судруудыг бэлэглэсэн аж. Тэрээр Ялгуусан хутагтад залагдахынхаа өмнө ус, сүв хоёрыг нийлүүлж хярам болгосон гэмээ залруулж уг хярамаа буцаан сүв, усыг тус тус саванд ялган хийсэн хосгүй удис, бурхан номын адис жанлавыг нь шавь, сүсэгтэн олон биширч “Ялгасан гэгээн” хэмээх хүндэт алдрыг өргөмжилсөн юм гэдэг.

Ялгуусан хутагтын шавийн хүрээ нь Цамын бүжгийн хөгжим, бүжгийн дэгийн цоо шинэ хэлбэрийг бий болгож хөгжүүлсэн гэх ба хийдийн, гэгээний шүтээн дуган, цогчин дуганы хэлбэр хийц маш гайхалтай, ерэн тохой Майдар бурханы жааз ямлай найман талтай, тал бүр нь өөр өөр өнгийн дуу гардаг том хонх, дөрвөн үхрийн ширээр бүрсэн хүрээ хэнгэрэг, 60 хөхүүр айраг багтдаг ваар, дөрвөн хүн дамжлан өргөдөг данх зэргээс гадна Ганжуур, Данжуурын бүтэн боть судар, есөн эрдэнэ шигтгэж урлан бүтээсэн “Жадамба” судар зэрэг ховор бүтээлүүд байжээ. Энэ хийдийн дэргэд арван найман нас хүрээгүй банди нарт монгол бичиг үсэг заадаг сургууль хичээллэдэг байв. Энэ хийдийг 1938 онд устгажээ.

Ялгуусан хутагт Чимидцэрэн хутагт Богд хаант Монгол улс, БНМАУ-ын эхэн үеийн харьцангуй богино хугацаанд боловч ихээхэн зүйлийг бүтээсэн нэрт хутагт билээ. Ялгуусны шавийн хүрээний сайн лам Санжаахүү олон жил лам нарын ахлагчаар томилон уул сүмийн хурлыг таслалгүй залгуулж байснаас гадна Гэсэрийн сүмийг засах ажилд хамгийн их буюу дөрвөн лан таван цэнг Чимидцэрэн хутагт, гурван лан таван цэн мөнгийг Жалханз хутагт тус тус хандивлаж байжээ. Чимидцэрэн хутагт 1916 онд Нийслэл хүрээний шинэ сумийн барилгын үйлдвэрт 100 лан мөнгө туслан барьжээ. Мөн олноо өргөгдсөний наймдугаар он 1918 онд улсын санд их хэмжээний мөнгийг хариулан барьсан байна. Ардын хувьсгалын үйл хэрэгт оролцож Ялгуусан хутагтын шавиас цэрэг татах, цэргийн хоол хүнс гаргах, уналга хөсөг бэлтгэхэд хошуучилж байснаас гадна Улиастайд бүгж байсан Вандановын зэвсэгт бүлгийг дарах Монгол цэргийн бослогод Ялгуусан хутагтын шавь сайтар оролцсон байдаг. 1921 онд Хатанбаатар Магсаржав Ялгуусан хутагтын шавийн хүрээнд дөхөж ирээд Яруугийн хүрээ рүү буцах үед цэргийн хэрэглэлд сайн дураар тусалж, гэгээний сангаас хүнсний мал, уналга морьд, мөн Нийслэл хүрээнээс Улиастай орох Монгол цэргийн хэрэгцээнд агт морь хорь, амбан шар наймыг гэгээний жасаас гаргаж өгчээ. Ховд, Улаангомын чиглэлд байлдах зүүн аймаг, хошуудын цэргийг буцахад, мөн улаан орос цэргийн хэрэгцээнд туслах уналга, хүнсний мал, мөнгө гаргах үүргийг онцгой сайн гүйцэтгүүлсэн байна. 1922 онд улсын санг зузаатгахын тулд “Ард олноос татварлан авах мөнгөний тухай түр дүрмийн” дагуу Ялгуусан нутагтын шавь нар 1188 лан мөнгө гаргаж нийлүүлжээ. Аймгийн намын хороо байгуулах хуралд төлөөлөгч болгон гэгээний шавиас Эрэн зайсан, Сэрээтэр донир нарыг томилон явуулж намын олон нийтийн саналын олонхыг дагнана гэсэн утга бүхий санал өгч байв.

Ялгуусан хутагтын шавь хошуу 1918 оны байдлаар 262 өрх 1387 хүн ам, үүнээс сул харчуул 493, лам банди нар 229, бүх эрчүүд 722, эмс охид 570 гэж тоологдсон ба мал нь адуу 2702, тэмээ 122, үхэр 4722, хонь ямаа 13997, бүтд 21543 толгой малтай байжээ. Ялгуусан хутагт Чимидцэрэнгийн хувийн мал сүрэг энэ тооллогоор адуу 286, тэмээ байхгүй, үхэр 208, хонь ямаа 1047 бүтд 1541 толгой тоологдсон аж.

Ардын засгийн газраас хувьсгалт эрдчилсэн өөрчлөлт хийж эхэлсэн 1923 онд Ялгуусан хутагтын шавийн хошууг Хантайшир уулын аймгийн Нөмрөг уулын хошууны Идэрцэрлэг сум болгон байгуулж, хутагт хувилгаадын төрийн талын эрх мэдлийг хумьж, зөвхөн сум хийдийн хурал номын ажил эрхлэх үүргийг үлдсэн билээ. Яг энэ үед Ялгуусан хутагт Чимидцэрэн арван нэгэн настай балчир ахуй насандаа төрийн хэргээс чөлөөлөгдөв. Ялгуусан хутагт Чимидцэрэн эрүүд чийрэг, сэргэлтэн авхаалжтай, ой сайтай, хурал номын сургуульд сайтар боловсорч байсан, бага уншлага дүүргэж, их уншлагад орж эхэлж асан үед нь сум хийд, хурал номын ажллагаа зогссон юм

Чимидцэрэн хутагтыг 1930, 1937, 1938 онд гурван удаа баривчилж хилс хэрэг тулгаж, хоёр удаа 25 жилийн хорих ял шийтгэж, эцэст нь 1938 оны дөрөвдүгээр сарын 24-нд Идэр сумын есдүгээр багийн нутаг Бумбан хэмээх газраас гэрээс нь баривчилж, аймгийн шоронд хорьж хоёр сарын дотор хоёр удаа буюу тавдугаар сарын 21 ба 25-нд байцаан мэдүүлэг авч, "морь 2, гvv 1, бага удаа 2, үхэр 3, хонь ямаа 6, эсгий гэр 1, авдар 3, модон ор 1, ширдэг 2, мөнгөн тоногтой эмээл 1, мөнгөн аяга 1" гэх хөрөнгийн акт тогтоосноор хэрэг бүрдүүлж, "нам, засгийн бодлогыг эсэргүүцсэн, олон түмнийг хол хөндий байлгах, итгэл алдуулах санаа агуулсан, засгийн хүч чадлыг тагнах бүлэг байгуулж зэвсэгт бослогод бэлтгэсэн, Ялон, Манжийн цэрэг ирж нам засгийг устгах болно гэх мэтийн цуурхал тараасан, Ванчин Богдыг залж нам, засгийг үгүй хийх хурал ном үйлдсэн, зэвсэг цуглуулсан, 300 төгрөгийн үнэтэй гансаа хадам эцэгтээ дамжуулж хөрөнгө дарагдуулсан" гэх мэт хэргээр хилс хэрэг тулган хүлээлгэж шvvх цаазын бичгийн 4347 дүгээр зүйлээр ял төлөвлөж Дотоод явдлын яамны бүрэн эрхт онцгой комиссын 1938 оны зургадугаар сарын 10-ны өдрийн 22 дугаар хурлаар батлуулж, 25 настайд нь хуулийн дээд хэмжээ цаазаар авах ял оногдуулж, егүүтгэсэн байдаг. 1992 оны наймдугаар сарын 20-ны өдрийн Улсын дээд шүүхийн цэргийн коллегийн 144 дүгээр магадлалаар Чимидцэрэнг улс төрийн хэрэгт холбогдолгүй болган цагаатгасан байна. Ялгасан гэгээн Чимидцэрэн цагийн үймээн, ертөнцийн жамыг дагаж буруудаж зөвдөж явсан эр хүний хувьд гурван удаа гэрлэж, хоёр хvvхдийн эцэг болж явжээ. Түүний охин Лхамсүрэн, ач зээ нар нь олны ачаар сайн сайхан явна.

Ялгасан гэгээн Чимидцэрэнг сэнтийд нь залж суулгасны 90 жилийн ойг тэмдэглэж сүсэгтэн олон, үр хvvхэд, нутгийн зөвлөл, нутгийн уугуул, санаа сэтгэлт түмэн олон сэдэж Чимидцэрэн хутагтын тухай "Ялгуусан хутагт Чимидцэрэн" баримтат кино, "Ялгуусан хутагт, Ялгасан гэгээн Чимидцэрэн" ном, "Ялгуусан хутагтын заллага" хэмээх дуу бүтээж, Ялгуусан хутагтын шавийн хүрээний буурин дээр дурсгалын гэрэлт хошөө босгожээ.

Дээр өгүүлсэн Сайн ноён хан аймгийн Ялгуусан хутагтаас гадна Монголын шашны түүхэнд Сэцэн хан аймгийн Ялгуусан хутагт, Чин сүжигт номун ханы хүрээнд залагдаж байсан Ялгуусан хутагт Жамъянлодойнамжил гэсэн нийт гурван ялгуусан хутагт лавтай байсан гэдэг.

Монголд тодорсон хувилгаадын сэнтийд суусан хугацаагаар Ялгуусан хутагт 261 жил, Жалханз хутагт 246 жил, Нарванчин хутагт 205 жилийг эзэлсэн байдаг. Өргөмжлөлт хутагтуудын сvvлчийн дүрийн тодорсон хугацаа Ялгуусан хутагт Чимидцэрэн 1915 онд, Нарванчин хутагт Жvгдэржамжил 1904 онд, Дилав хутагт Жамсранжав 1888 онд тодорсон отгон дүрийн хутагт байсан юм.

XX зууны эхээр Монголын автономыг сэргээх үндэслэлийг тодорхойлсон Богдын

бичгийг үйлдсэн дөрвөн хүний хоёр нь эгч дүүгийн хүүхдүүд болох алдар цуут хоёр хутагт Жалханз хутагт Дамдинбазар, Дилов хутагт Жамсранжав нар байсан юм.

Жалханз хутагтын Монголд хувилсан анхдугаар дүр Лувсанданзанжамц урьд Энэтхэг, Төвдөд 14 удаа хувиран төрж байсан ба Монгол Жалханз хутагтын өмнөх дүр Гандан ширээт лам Жалханз Балжиржамц нь Төвд орны шар малгайтны ёсны гол хийд Гандан хийдийн 25 дахь ширээт лам байсан бөгөөд Төвдийн номын мэргэдийн дунд ихээхэн алдартай лам байжээ. Жалханз хутагтын Монголд хувилсан 8 дүр нь:

- 1-р дүр Лувсанданзанжамц (1634-1654)
- 2-р дүр Лувсанданзанбалсан (1656-1740)
- 3-р дүр Ишгэлэг (1740-1746)
- 4-р дүр Галсамдамба яринпил (1746-1794)
- 5-р дүр Лувсанбалжирхүндэв (1797-1847)
- 6-р дүр Чойнпилжанцан (1848-1854)
- 7-р дүр Чойжигжалцан (1857-1872)
- 8-р дүр Дамдинбазар (1874-1923) нар юм.

Анхны дүр нь 1634 онд Засагт хан аймгаас Жалханз хутагтын дүрд тодорсон Лувсанданзанжамц юм. Тэрбээр 1654 онд наснаас хальжээ. Түүнээс хойш Жалханз хутагтын дүрээр 1656-1740 онд Лувсанданзанбалсан, 1741-1745 онд Ишлэг, 1746-1794 онд Галсамдамба-Яринпил, 1796-1846 онд Лувсанбалжирхүндэв, 1856-1873 онд Лувсанжалцан тус тус тодорсон байдаг. Манж эзэн хаан зарлиг гарган 1824 онд Жалханз хутагтад шавь захирах тамга олгосон байна.

Шашин төрийн нэрт зүтгэлтэн, Монгол улсын гурав дахь ерөнхий сайд Номухан самади багш, Монгол дахь Жалханз хутагтын наймдугаар хувилгаан дүр Дамдинбазар нь Засагт хан аймгийн 5 хотгойдын нэг – гүн Загдсамбарын Нөмрөг хошуу нутаг, одоогийн Завхан аймгийн Нөмрөг сумын Ойгон нуурын урьдах Бурын толгой гэдэг газар 15-р жарны модон эр нохой жилийн зуны эхэн сарын 29 буюу 1874 оны зуны тэргүүн сарын 29-нд эцэг Цэрэнсодном, эх Соном нарын гэр бүлд мэндэлсэн аж. Энэ үед Халх даяар Жалханз хутагт Лувсанжалцангийн хойд дүрийг идэвхтэй эрж хайж байсан бөгөөд хутагт тодруулах хүүхдүүдээс Дадинбазар шигшигдэн, олон шат дамжлагыг давж, Халх Монгол дахь Жалханзын найм дахь дүрээр 1877 онд 3 настайд нь тодруулж, эцэг, эхийн хамт Жалханзын хүрээ, одоогийн Хөвсгөл аймгийн Бүрэнхаан сумын нутагт оршиж байсан Равданчойнхорлон хийдэд хутагтын сэнтийд залсан байна.

1884 онд 10 гаруй наснаас нь монгол, манж, түвд хэл бичиг, шашны ёс жаяг, бурхны ном сургаалаас эрдэм чадал бүхий лам хуврагууд нарийн хуваарийн дагуу хичээл зааж, зурхай болон гүн ухаан, билэг баримадын номлол, чойрын ном, учир шалтгаан, сахил санваарын ёс горим, хүн судлал зэрэг арга ухаанд эрчимтэй сургажээ. Дамдинбазарт эрдэм ном заасан гол багш нь их номч мэргэн Жигжид, Агваанжамц, Минжвүрдорж, Лувсанданзан нарын Монголын эрдэмтэй лам нар байв. 1893 онд 19 насандаа хутагт Жавзундамба богдын шадар хамбын нэг болж түүний дэргэд ажилласан байна.

Жалханз хутагт өөрийн хүрээ хийддээ 24 баримал бурхан, 20-иод зурмал бурхан бүтээлгэж, 700-гаад боть судар номын хамт залж байжээ. Мөн өөрийн оюун билэг ухаанаараа шашин, түвх, гүн ухааны болон зан үйл, ёс суртахууны сэдэвтэй «Билгүүн хүрд», «Багшийг шүтэх ёсон», «Эрдэнийн сан хайрлагч», «Бусдад туслах зүрх», «Билгийн гал», «Хүслийг хангагч сайн хумх», «Мэсийн хүрд», «Нигүүлсэнгүй цэнгэлт далай» зэрэг олон ном бүтээл туурвисан байна.

Жалханз хутагт Дамдинбазар бээр 3 төрийн үед сайдын алба хашиж байсан нь:

1. 1892 онд буюу Манжийн хааны үед баруун хязгаарыг хариуцсан Түшмэл сайдаар томилогдон ажиллаж байх үедээ, 1897 онд 23 насандаа Тамгатай хутагтын хувьд Бээжинд явуулсан нэгэн бичигтээ «Манжийн явуулж буй бодлого, харгис дарангуйлал цааш үргэлжилбэл монголчууд зэвсэг барин тэмцэхээс өөр аргагүй болно» (УТНС (гар бичмэлийн фонд) 1373(96) гэжээ.

2. 1912 онд Богд хаант Монгол Улсын баруун хязгаарыг илбэн тохинуулах сайдаар томилогдож, Хүрэннээс 500 цэрэг авч Ховдод очин, Монголын тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болсон Алтан соёмбот тугийг мандуулж, манж, хятад түшмэд, цэргийн эрхтнүүдийг тус хотоос хөөн явуулж, Ховд хотыг чөлөөлөх, Баруун хязгаар нутгийг тохинуулахад онц гавьяа байгуулсан учир Богд хаан зарлиг гарган Дамдинбазарт Самадн багш номун хан цол олгожээ. Түүнийг Хүрэннээс Улиастайг дайран Улаангомыг чиглэн хөдөлсөн зам зуурт лам, ноёд олон хувьдстэй уулзан учирч, дөрвөд Далай хан Галсаннамжил, түвний ахмад хүү гүн Түмэндэлгэржав нар хутагтын үгийг дагаж дөрвөд, баяд 700 цэргээ авч хутагтыг дагаснаас гадна урианхай Гомбодорж 300 цэрэгтэй, Ши бэйс 300 цэрэг авч зам нийлсэн байна. Хүрэннээс Улиастайг дайран Улаангомыг чиглэн хөдөлсөн. Зам зуурт лам, ноёд олон хувьдстэй уулзан учирчээ. Дөрвөд Далай хан Галсаннамжил, түвний ахмад хүү гүн Түмэндэлгэржав нар хутагтын үгэнд итгэж дөрвөд, баяд 700 цэргээ авч хутагтыг даган явах болжээ. Бас Урианхай Гомбодорж 300 цэрэгтэй, Ши бэйс 300 цэрэг авч зам нийлсэн байна. Мөн 1912 оны тавдугаар сард Засгийн газраас томилогдсон цэргийн дарга С.Магсаржав, Ж.Дамдинсүрэн нар Хүрэннээс 500 цэрэг авч Ховдод очжээ. Дамдинбазар хутагт 1915 оны Хиагтын гурван улсын гэрээг шийдвэртэй эсэргүүцэгчдийн нэг байснаас гадна 1920 онд Богд эзэн хааны даалгавраар Дамдинбазар бусад нөхдийн хамт Дундад Иргэн улсад очиж, Богдын гарын всэг тамгатай бичгийг гардуулах, Монголын бие даасан эрхийн асуудлыг ярилцсан, мөн Америкийн дипломатуудтай холбоо тогтоосон байна.

3. 1922-1923 онд Монгол Улсын ерөнхий сайдаар томилогдон ажиллаж, 1922 оны гуравдугаар сарын нэгний өдрийн Ардын Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 5-р хурал, мөн сарын гуравны өдрийн Засгийн газрын 7-р хурлын шийдвэрээр ерөнхий сайдаар Дамдинбазарыг тохоон тавьж, Жалханз хутагтыг нийслэлд авчрах үүргийг Намын төв хорооны дарга С.Данзан эрхлэн гүйцэтгэсэн гэдэг. Номун хан Ерөнхий сайд Дамдинбазар Засгийн газрын хуралдааныг долоо хоног бүр хийх тогтсон өдөртэй болгон, хурлаа даргалж хамт олноор асуудлыг шийдвэрлэх болгосноос гадна 1922 онд хамжлагат ёсыг халах, улсын сахилга батыг чангатган сахих, орон нутагт сонгууль явуулах зэрэг олон шийдвэр гаргасны дээр «Нутгийн захиргааны дүрэм», «Гадаадын иргэн, тэдний үржлийн малаас түрээс хураах дүрэм»-үүдийг баталж, залуучуудыг гадаад орнуудад явуулан сургах болж, Орос, Герман мэтийн орнуудад тэднийг илгээжээ. Засгийн газраас Зөвлөлт Орос, Англи, Америк, Герман зэрэг орнуудтай тэгш эрхтэйгээр харилцах бодлого баримталж, Орос оронд тохиолдсон өлсгөлөнд туслах, Германаас эрдэмтэн урьж ирүүлэх, Америк улсын Эндрюсын экспедицээс дэлхийн бодис зэргийг шинжлэхэд тус дэм үзүүлэх мэтийн баримт бичигт гарын всгээ зурсан байна. Орон нутгийн засаг захиргааг шинэчлэх, удирдлагыг нь сонгож байгуулах саналыг олонтаа гаргаж байжээ. Монголын нийгэмд тодорхой өөрчлөлтүүд гарч нийгэм маань ардчилах тийш илэрхий хандаж эхэлсэн үед Ерөнхий сайд Дамдинбазар 1923 оны зургадугаар сард 50 насандаа гэнэт учир битүүлгээр жанч хальжээ.

Түүний хойно Жалханз хутагтын IX дүрийн хувилгаан Гилэгдэмбэрэлийг тодруулж залсан тухай Үндэсний Төв Архивийн Эрдэнэ шанзодвын данс А72-т Хан тайшир уулын аймгийн Дэлгэр хан уулын хошууны Дашлин хийдийн мэдээчинээс уламжлан Жалханз хутагтын хойд хувилгааныг тодруулсан учрыг гаргаж харьяат шавь нарын хүссэн ёсоор залуулахыг эрж өргөсөн бичгийг Бүтд Найрамдах Монгол Ард Улсын Бүх Шашны Хэргийг Эрхлэх Газар өргөн барьсан тухай баримт байгаа аж. Түүнд: хар шар олон шавь нар харьяат

багш хутагтын хойд дүрийг олж тодруулан залахыг хүсч, ойр орчмын хошуудад төрсөн бага насны хөвгүүдийн дотроос шинж билэг төгөлдөр хөвгүүд дотроос Наранжаргалант уулын хошууны Дэлгэр уулын сумны Баатарын аравны хүүхэн Саруулын дөрвөн настай хөвгүүн Гэлигдэмбэрэл гэгч хөвгүүний шинж билэг төгөлдөр хэмээхийг удаа дараа сонсож мэдэцгээж харъяат хутагтын хойд хувилгаан мөн хэмээн хэлэлцэж, Дэлгэрхан уулын хошууны Дашлин хийдийн тэргүүдэгчид Гэлигдэмбэрэлийг харъяат шавь нарын хүссэн ёсоор болгон залуулахыг тогтоон шийтгэж, дагаж явуулахыг гуйн өргөсүтэй үүний тул өргөвэй гэх мэтээр бичжээ.

Жалханз хутагтын үеэл Дилов хутагт Жамсранжав мөн л Засагт хан аймгаас төрсөн нэрт хутагтуудын нэгэн билээ. Дилов хутагтын анхны дүр Эртний Энэтхэгийн 84 шидтэний нэг Дилов Шаравсамбуугийн хувилгаан дүр Төвдөд Живзун Доринба, Дүлзэнлодойлэгсан зэрэг дүрээр хувилан төрж байгаад Монголд хувилсан анхны дүр - Эрх Цорж Наваанданзанжамц нь Өвөр Монголын Ордос, Урад дунд гүний хошууны нутагт хувилан мэндэлжээ. Хоёр дахь дүр Махурда мөн Ордост, гурав дахь дүр Дамчааярингэл Халхын газар, дөрөв дэх дүр Раашпунцаг Өвөр Монголд мэндэлжээ.

Тав дахь дүрийн Дилов хутагт Жамсранжав нь түрүү дүрийнхээ Дилов хутагт болон Наробанчин гэгээн хоёул жанч халсан 1884 оны хөх бичин жилийн аравдугаар сарын 8-ны луу цагт наран мандах үед Засагтхан аймгийн гүн Загдсамбарын Нөмрөг хошуу, одоогийн Завхан аймгийн Түдэвтэй сумын нутаг Ойгон нуурын хөвөө Баян айраг уулын өвөрт эцэг Башлуугийн 67, эх Гимбээгийн 48 насан дээр эрдэнэт хүний биеийг олж ах, эгч хоёрынхоо хойноос айлын гурав дахь хүүхэд болон мэндэлсэн бөгөөд түүнийг тиөрөхөд гэрийнх нь тооноор цагаан гэрэл сацарч байсан гэдэг. 1887 онд дээрхийн гэгээний алтан савханд онцгой төрсөн 40 гаруй хүүхдийн дотроос түүний нэр шингэж Хэрүгэ Дэмчиг бурхан - Дилов хутагтын бүрэлба хувилгаан дүр мөн хэмээн тодорсон байна. Тэрээр 5 настайдаа Төвд хэл сурч, 6 настайдаа 3000 шоголтой ном тогтоож, 7 насандаа цээжилсэн номоо ихэнхийг Монгол руу орчуулж, 12-тойдоо Төвдээс Монгол руу, Монголоос Төвд рүү судар орчуулж чаддаг болсон гэдэг. Мөн 7 настайдаа равжун, 21-тэйдээ гэцэл сахил, 25-тайдаа цорж, 29 насандаа самади багш цол хүртжээ. 7-11 насандаа Засагт Ханы Хошуу, Эрдэнэзуугийн хийд зэрэг газруудад залагдан Мандал өргөх ёслол, өргөл мөргөл, тахилгын ажлуудад оролцон, 11 настайгаасаа хурал номын ажлыг удирдаж судар бясалгадаг болжээ. Дилова хутагт Жамсранжав нь өөрийн төрсөн газраас нь 30 орчим бээрийн зайд орших Наробанчин гэгээний хийдэд залагдан сууж байсан аж.

Тэрээр 18 настайгаасаа шашны үйл хэргийн зэрэгцээ Гадаад Монголын өөртөө засан тохинох асуудлаар Улиастай болон Ховдод чуулган хэлэлцээнд оролцдог болсон аж. Дилова хутагтын 28 настайд буюу Манжийн ноёрхлын сүүлийн жил 1911 онд Хятадаас Монголыг тусгаарлан зарлаж хүрээний Богдыг хаанаар өргөмжилжээ. 1917, 1919 онуудад тэрээр Богд хааны зарлигаар Ар Монголын баруун хойт хязгаарт хятадуудын гаргасан үймээн, мөн Урианхайд лам нарын мөргөлдөөн зэргийг дарахад Хатанбаатарын хамт түүний "орлогч жанжин - цэргийн лам"-аар ажиллаж эдгээр үймээнүүдийг дарахад оролцжээ. 1920 онд Дилова хутагтыг Богд хаан дахин дуудуулсан нь Хятадын ерөнхийлөгчийн амрыг айлтгахын сацуу Хятадын албаны хүмүүс болон ялангуяа Америкийн төлөөлөгчидтэй уулзан Монголын автономит эрхийг сэргээхтэй холбоотой асуудлаар төлөөлөгчдийн хамт Бээжин явах томилолт байлаа. 1923 онд Улиастайн сайдаар ажиллаж байв. "Хатанбаатар Магсаржав, Бодоо нартай хамт Орос Улсаас тусламж гуйхаар яваад албан бичиггүй хэмээн Хиагтын хил дээрээс буцаж байсан" гэх баримт ч намтар нь байдаг гэнэ.

1922 онд Ижил мөрний торгууд Дамбийжанцан Ховдын хязгаарт үймээн дэгдээж дээрэм тонуул хийж, хүмүүсийг тарчилган алж түүний захиргаадалтаас айсан Ховдын умард хэсгийн Өөлд, Дөрвөд, Хасагууд нутаг орноосоо оргон дүрвэж Дамбийжанцан тэднийг мөрдөн мөшгиж барьж, амьдаар нь арьсыг нь хуулах зэрэг харгислал хэрээс хэтэрсэн тул түүнийг

устгах онцгой даалгавар мөн л улсаас тэр үеийн Улиастайн сайд Ламжаваар дамжуулан Дилова хутагтад иржээ. Дамбийжанцан шашны цол хэргэмээр нь Дилова хутагтыг хүндэлдэг байсан тул үүнийг далимдуулж Дилова хутагт “Монголын шинэ засгийн анхны ерөнхий сайд Жалханз хутагт танд шагнал гардуулахаар Хүрээнд урьсан хэмээн...” урилгын бичиг найруулан бичиж Дамбийжааг тонилгох хүмүүс энэхүү тамгатай бичгийг нь авч Дилова хутагтын элч төлөөлөгч болж итгэлийг нь олж гэрт нь ороод түүнийг устгасан гэдэг. Хожим нь тэрээр 1931 онд хилсээр хоригдон байцаагдаж байхдаа оргодол Дамбийжанцантай холбоо сүлбээтэй байсан гэсэн ял тулгахад “-холбоо сүлбээтэй байх нь битгий хэл улс орныхоо амар тайван байдлын төлөө бурханы үйлдэмгүй хэргийг яахын аргагүй өөрийн гараар үйлдэж түүний үхэлд би оролцсон доо” хэмээн их л гунигтай өчсөн гэдэг.

1922 онд тэрээр Улиастайн сайдаар томилогдож жил хэртэй ажиллаад уг албанаас чөлөө хүсч Нарованчин хийддээ сууж зовсон ядарсан олонд буян үйлдэж хурал хурж ном айлдан, судар бясалгажээ. 1928 онд хэлмэгдүүлэлтээр бүх хөрөнгөө хураалгаж 1930 онд тайж Эрэгдэндагвын хэрэг гэгчээр хотод дуудагдан нэг жилийн турш байцаагдан хоригджээ. Түүнтэй хамт Халхын том лам нар болох Егүзэр хутагт, Манзушир хутагт нар хоригдож байсан ба Эрэгдэндагвын хэргийн шүүх хурлаар Егүзэр хутагт нарын долоон ламыг 24 цагийн дотор буудан алах харин Манзушир хутагтыг арван жилээр хорих Дилова хутагтыг таван жилээр хорих ялыг тэнсэн харгалзжээ. Тэнсэн харгалзах гэдэг хэрвээ дахин баригдах шалтгаан гарваас түүний цаана шууд алах ял байгаа нь ойлгомжтой, түүнийг эрт оройгүй хэзээ нэгэн цагт дахиад баривчлана гэдгийг тэрээр сайн мэдэж байв. Үнэнийг хэлэхэд Манзушир хутагтад яг ийм тавилан оноогдсон билээ, түүнийг 1938 онд Гэндэн Дэмидын хэргээр дахин баривчилж хороосон юм.

“Ванчин Богд 10 мянган цэрэгтэй Монголын урд хилд ардын засгийг устгахаар зэхэж байна” зэрэг цуурхал манай улсад дэгдээд байсан нөхцөл байдлыг тухайн үед Дотоодыг хамгаалах газар шийдэхдээ тагнуулын үйл ажиллагаагаар Ванчин Богдын үзэл бодлыг мэдэж, дүрвэн гарсан иргэдийн байр байдлыг судлах хэрэгтэй гэж үзээд Ванчин Богдод итгэл олж харилцаа тогтоож чадах хүнийг ганцхан Дилов хутагт хэмээн үзэж 1931 оны 2-р сарын 26-ны өдөр түүнийг Монголын өмнөд хил давуулан үджээ.

Судлаач С.Энх-Амарын тэмдэглэснээр: “Эрдэм чадлаараа Халхад алдаршсан хутагтыг 1930-аад онд “Эрэгдэндагвын 38-ын хэрэг” гэгчээр баривчилж, тэнсэн харгалзаж байв. Хамаг эд хөрөнгөө ардын засагт хураалгасан Эрэгдэндагва тайж Төвдийн Банчин Богдод Монгол түмний амьдрал доройтож буйг дурдаж, аврал өршөөлдөө багтаахыг гуйсан захидал илгээх санаа сэджээ. Тэр хэрэг гэгчээр далимдуулан Халхын тамгатай 13 хутагтын нэг Егүзэр хутагт Галсандашийг хүртэл буудан хороож байжээ. Тийм хэцүү цагт амь аврагдана гэдэг чухамдаа бурхны хишиг байсан хэрэг шүү дээ. Ийн амь хэлтэрсэн хутагтыг Дотоод яамнаас Банчин Богд, гоминданы Хятад, Өвөр Монголд нэвтэрч байсан япончуудыг тагнуулахаар өмнө зүгт илгээсэн байдаг. Түүний амь нас, аюулгүй байдлыг хангах зорилгоор “Дилов хутагт эх орноосоо урважээ” гэсэн худал цуурхал тараасан байна. Хэдийгээр энэ явган яриа хуурай өвсний түймэр мэт тархаж, хилийн дээс давж харийнханд итгэл үнэмшил төрүүлсэн ч хожим нь их хутагтын нэрэнд хар толбо, сэтгэлд бул чулуу болж хоцорсон юм. Хамгийн харамсалтай нь, тэрбээр эх нутагтаа хэзээ ч эргэж ирэх боломжгүй болж, “оргодол” хэмээх муу нэр үнэн мэт болж хувирсан билээ. Энэ бол үнэхээр эмгэнэл байсан гэж хэлж болно. Дилов хутагт 1931 оны хоёрдугаар сарын 26-ны шөнө эх орныхоо хилийн алтан дээсийг алхан гарахдаа “хэзээ ч эх нутагтаа эргэж ирэхгүй” гэж огтхон ч төсөөлөөгүй нь лавтай. Тэрбээр хүн болж, хүй цөглөсөн эх нутагтаа эргэж ирэхийн хүслэн хязгааргүй их байсан ч түүнд хүндтэй даалгавар итгэж өгсөн хүмүүс цөмөөрөө хэлмэгдлийн хар шуурганд өртөж, түүний “урвагч-оргодол биш, эх оронч-тагнуулч” болохыг гэрчлэх хүн үгүй болжээ. Өнөөгийн өндөрлөгөөс харахад “эргэж ирээгүй нь тун оносон зөв шийдвэр байжээ” гэж бодогддог. Ирэнгүүт нь өнөөх “оргодол” гэдэг нэрээр бамбай болгон баривчлаад буудчих байсан ч юм бил үү. Цөвүүн цаг байлаа шүү дээ. Өмнөдөд байхдаа

“дэслэгч Жамсран”, “гүн” гэх нууц нэрээр мэдээлэл ирүүлж байсан тухай баримт эдүгээ ч тагнуулын байгууллагын сан хөмрөгт хадгалагдаж байна. Хожим нь 1990 онд түүнийг цагаатгаж, нэг насаар нь хүзүүнээс нь зүүсэн “урвагч-оргодол” гэх пайзыг авч хаясан билээ. Өмнөд нутагт тэрбээр муу амьдарч явсангүй. Угаас зовхи нь өөдөө хүмүүн болохоор Банчин Богд, Чан Кайши, Далай лам тэргүүтний дэргэд шадарлаж, төр, шашны үйлсэд оройлон зүтгэж байсныг түүх гэрчилдэг. Тийн байх цагтаа Америкийн Монголч эрдэмтэн О.Латтимортой танилцсан нь түүний амьдралын шинэ үеийг нээсэн байна. Нэр хүндтэй тэрхүү эрдэмтний урилгаар Америк оронд морилж, Балтимор хотын Жонс Хопкэнсийн их сургуулийн Монгол судлалын тэнхэмд ажиллав. Энэ хоёр их хүн амьдралынхаа сүүлчийн өдөр хүртэл дотно нөхөрлөж, хамтран ажилласан байдаг. Энэ бол жинхэнэ эр хүмүүсийн нөхөрлөл байлаа. Дараа нь Нью-Жерси мужид халимагуудын байгуулсан буддын сүмд хамбын олбог дээр сууж байлаа. 1960 онд Чан Кайшитай зөвлөлдөн байж “Монгол бусад тусгаар тогтносон улс гүрний адил НҮБ-д бие даасан гишүүн байж болно” хэмээн хүлээн зөвшөөрүүлсэн түүхэн гавьяа их хутагт Жамсранжавынх байлаа. Чан Кайши Монгол Улсыг хүлээн зөвшөөрөхгүй хэчнээн ч жил боллоо доо. Монголыг олон улсын хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүнээр баталсан НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганы хуралдааны танхимын арын эгнээнд нэгэн хижээл Монгол эр үйлж суусан нь мөнөөхөн Дилов хутагт бөлгөө. НҮБ-ын төв байрны гадна ирээд хөх тэнгэрт зөөлөн салхины аясаар намуухан намилзах алтан соёмбот далбаагаа удаан харж зогсох тэр эрхэм бол мөн л Дилов хутагт байлаа. АНУ-д суугаа Монголын ЭСЯ-ны гадаах сандал дээр суугаад Монгол хүүхдүүдийн наадаж тоглохыг хашааны завсраар шимтэн харж баясч суусан том биетэй өвгөн бол Дилов хутагт байлаа... 1965 оны дөрөвдүгээр сарын 7. Түм түжигнэж, бум бужигнасан алс холын Нью-Йорк хотноо нэгэн их хүн бурханы хутгийг олж, тэнгэрт халив. Тэр бол энэ хорвоод хүн болж төрөөд 82 жилийг үдсэн Дилов хутагт Жамсранжав байлаа. Түүний хойдын буяны номыг 14 дүгээр Далай лам уншиж байв. Хутагт Лхаст гурван жил болохдоо Далай ламын гэрийн багш байж. Багшийн ачийг ийн санах нь хүмүүний ёсон билээ. Чандрын нэг хэсгийг буддын ариун дагшин орон Энэтхэгт цацаж, нөгөөг нь төрсөн эх орон Монголд нь хүргэх аятай цагийг хүлээв гэж түүхэнд өгүүлжээ. Түүний өөрийнхөө гараар бичсэн “Ар Монголын улс төрийн дуртгал” ном түүхэн ховор чухал баримт болж, үндэс суурийг нь тавьсан “Ницан” сүм Нью-Жерси мужид сүндэрлэж, амьдрал тэмцэл нь “Цагаан дуганын гэгээ”, “Хорвоод ховорхон хүмүүс” кино, “Хүн, бурхан, адгуусын орноор”, “Дилов хутагт” романд мөнхөрч, дүр төрх нь Улиастай хотын Жавхлант толгой дээрх цагаан суварганаа үүрд үлджээ”.

Монгол дахь улс төрийн нөхцөл байдлын эрхээр 1931 онд Монголоос гарч, Энэтхэг, Балба, Хятад орнуудад суурьшиж байгаад 1941 оноос Хятадын ерөнхийлөгч. Чан Кай Шигийн дэргэд 6 жил зөвлөх хийхдээ 1946 онд Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлсэн түүхэн гавьяатай хүн юм. 1949 онд Монгол судлаач, Оуэн Латтиморын урилгаар АНУ-д амьдрах болсон байна. Тэндээ Жон Хопкэнсын их сургуульд Монголд судлалын тэнхимд зөвлөхөөр ажиллаж байгаад 1952 онд Нью-Жерси мужид бурхан шашны сүмийг (Дашгепеллин дуган) үүсгэн байгуулж, хамбын суудалд сууж АНУ-д шарын шашин дэлгэрүүлэхэд Америкийн халимагуудын хамт зүтгэж ирсэн байна. Тэрбээр амьдралын сүүлчийн жилүүдээ харийн оронд өнгөрүүлж 1965 онд АНУ-ын Нью-Йорк хотод таалал төгссөн юм”.

Богдын тамгатай Хутагтуудаас хамгийн түрүүнд 1930 онд буудатдсан 25 настай Зая бандит хутагт Жамбацэрэн байв. Орос хэлтэй, европ маягаар хувцасладаг энэ хутагт маш их эрдэм номтой, ирээдүйг зөгнөх ид шидтэн байв. Тэрбээр 1905 онд Цэцэрлэг мандал, одоогийн Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг “Мэндийн овоо” гэх газар Лхамсүрэнгийн анхдугаар хvv болон төрж, таван настай байхад нь нутгийн лам хуваргууд хутагтын хойт дүрээр тодруулж, эрхэм сэнтийд залсан ба хар багаасаа эрдэм номтой лам нараар бичиг үсэг заалгаж, Монгол, төвд хэл бичиг төдийгүй орос хэлийг төгс эзэмшин, орос ном зохиол уншиж судалдаг

дэвшилтэт үзэлтэй хүн байжээ.

Жамбацэрэн гамин, Бароныг хооход идэвхийлэн оролцож унаа мал, хоол хүнээр хангах, цэрэг эрсийг дайчлах зэрэг арга хэмжээг аймаг орондоо зохион байгуулж байсан нь архивын баримтуудаар нотлогддог. Хатанбаатар Магсаржавын журамт цэргүүд сүр хүчиндээ хэт итгэж зарим үед харгис дээрэнгүй хандахыг Заяа Бандид эрс эсэргүүцэж, Хатанбаатар вантай ам мурийсан тухай хууч яриа нутгийнхны дунд ам дамжин явсаар сүүлдээ чимэг хачир орон баяжинж үлгэр домог мэт болсон аж.

Олноо өргөгдсөний 1911 онд Заяа Бандид Жамбацэрэнг нийслэл хүрээнд татан авчрах бичигт: “16 настай Заяа Бандидийг засч залруулахын тулд нийслэл хүрээнд дуудан, хүрээний хэргийг хутагтын багш Дарва бандид захируулан тохируулах нь зүй” хэмээжээ.

1921 оноос хойш түүнийг дөрвөн ч удаа баривчлан цагджээ. Дахин дахин баривчилж, тагнаж цагдах учир Заяа Бандид арга буюу төрийн албанаас хөндийрөхөөр шийдэн 1922 онд залгамжилж ирсэн отго жинсээ халж, ноён хэргэмээсээ татгалзсан боловч “до” яамны мөрдлөгөөс салсангүй.

Түүний зохиосон нэгэн шүлэгт:

Шаргачин ханшийн жилд шар оросыг харав аа

Шавь нар болсон бид нар шажинг төгссөн мордъёо

Өглөө үдийн шүүдэр өвсөө чийгшүүлээд өнгөрнөө

Өнөө муусайн ардууд нь өглөө босохуйа хоосноо гэжээ.

1925 онд тэрбээр Засгийн газарт хандан бичсэн өргөдөлдөө: “Жилээс жилд цагийн аяс муудан, хутагт хувилгаадыг хялаан хавчих нь улам бүр газар авч буй нь цөвүүн цаг хаалга тогших дохио гэмээр намайг амар жимэр суулгасангүй. 1921-1924 оны өвөл баривчилж дотоодыг хамгаалахын шоронд хоёр дахь удаагаа өнгөрөөв. Хавар нутагтаа буцаж ирээд зунтай золгоюу гэтэл дахин дуудаж дотоодыг хамгаалахын шоронд “нууцыг задруулсан” хэмээх хэргээр зургаан сар суулгав” гэсэн байдаг аж.

Өдгөөгийн Цэнхэр сумын нутаг Цэцэрлэгийн голд амар тайван сууж асан Жамбацэрэнг сүүлчийн удаа баривчлах үед “Одоо ч би эргэж ирэхгүй биз ээ” хэмээгээд ээж болон ахан дүүстэйгээ салах ёс гүйцэтгээд мордсон гэдэг.

Тэр баривчилгаанаас хойш удалгүй Заяа Бандид тэргүүтэй “эсэргүү” нарыг шүүх хурал нийслэл хүрээнд их л сүр дуулиантай болсон байна. Заяа Бандид ном эрдэмтэйгээс гадна хүн бүрийн харааг булаасан гоолиг өндөр нуруутай, цэвэрхэн царай зүстэй, ёстой л Юндэн гөөгөө байсан гэж хүрээний хуучцуул дурсан ярьдаг байна. Ялангуяа бусгүйчүүд Заяа Бандидийг харах гэж хошууран дагадаг байжээ. Дээр өгүүлсэн дуулиант шүүх хурлыг одоогийн Ленин клуб буюу тэр үеийн нэрээр Орос клубт хийсэн бөгөөд бусгүйчүүд голдуу байсан гэдэг. Заяа Бандид гэх сайхан эрийг л харах гэж зүтгэн байж орсон хүрээний гангчуудын нэг Цэндсүрэн гуайн хуучилсанаар, “Заяа Бандид Жамбацэрэн гэж халхын цуутай сайхан эр байлаа, Хүрээний хүүхнүүдийн нүдийг булаасан ганган залуу гэлцэн ам дамжин шивнэлддэгсэн. Би тэр хүнийг үзэхсэн гэж мөрөөдөж л явлаа. Тэгсэн чинь нөгөө Жамбацэрэн хутагт эсэргүү болж гэнэ. Орос клубт хэргийг нь таслах юм байна гээд л шуугицгаах. Тэр өглөө нь хар үүрээр босоод, гэрийнхнээсээ нуугдаж Орос клубт очлоо. Хүн амьтан дүүрэн. Голдуу л залуу бусгүйчүүд харагдана. Арай гэж л багтаж орсон юмдаг. Жамбацэрэн үнэхээр сайхан залуу байсан даа. Богино халимагтай, өндөр гоолиг нуруутай, удаан хоригдож гундсан ч гэлээ өнгөлөг, цэвэрхэн цагаан царайтай, сайхан эр харагдаж байсан. Нүдэнд дулаахан тэр эрийн царай миний сэтгэлд хоногшин үлдсэнсэн. “Үгээгүй ардын ангийн хувьсгалын эсэргүү дайсан, шар харгисын нэгэн болох тул шүүх цаазын бичгийн тусгай ангийн 41, 42, 43 дугаар зүйлийг үндэслэн буудан алсугай” гэж уншихад хуралд оролцогсод дуу алдан, шогширч, толгой гудайлган, зарим нь

сэмхэн нулимсаа арчиж байж билээ. Дараа нь дуулахнээ Шар хад гэх газар буудан алсан гэх боловч хүмүүсийн дунд “цаазалж чадаагүй гэнэ. Гурав буудсан чинь гэгээнтэн шөнө нь гэртээ ирчихсэн байж гэнэ гэхчлэн цуу яриа газар авч “До” яамныхан ч нэлээд сандарсан байх. Ногоон малгайт Маахуур Дамба гэгч хүн цаазлахдаа гаршсан нэгнийг явуулан аль хэдийнэ таалал төгссөн гэгээнтний цогцсыг олж толгойг нь тасалж авч байсан гэдэг юм”. Ийнхүү Зая бандид ЖУамбацэрэн хутагтыг 1930 онд хилс ял тулган 25 насанд нь цаазаар авчээ.

Монголын нөлөө бүхий хутагт хувилгаадыг 1930 оноос эхлэн улс төрийн хэрэгт баривчилж шийтгэл хүлээлгэж байсны жишээ нь Халхын Өндөр гэгээн Занабазарын тэргүүн хоёр шавь Зая бандида Лувсанпрэнлэй, ламын гэгээн Лувсанданзанжанцан нарын хойд дүүрүүд болох Зая бандида Жамбацэрэн, ламын гэгээн Цэрэндорж нарыг улс төрийн хэрэгт баривчилж, шийтгэж хэлмэгдүүлсэн, мөн 1930 онд тайж Б.Эрэгдэндагва нарын 38-ын хэрэгт Монголын баруун, зүүн, төвийн ард олны дунд нэр хүнд өндөртэй дилов хутагт Жамсранжав, Егүүр хутагт Ж.Галсандаш, Манзушир хутагт С.Цэрэндорж нарыг оруулж, харгалзах ялыг ногдуулж хэлмэгдүүлсэн зэрэг юм.

30 орчим мянган хүнийг улс төрийн хэрэгт хэлмэгдэж, гэм буруугүй болохыг тогтоон цагаатгаад байна. Эдгээр 30 мянган хүнээс 17 мянга гаруй нь лам нар байсан бөгөөд үүний 14 мянгыг буудаж алсан хийгээд үлдснийг нь 10 жилээр хорих ялаар шийтгэж байсны дээр цөөн хүнийг 5 жил хорих ял оноож байжээ.

1990-ээд оны Монголын ардчилсан өөрчлөлтөөс хойш хэлмэгдсэн хутагт хувилгаадын хэргийг цагаатгасан юм. Мөн сүүлийн үед тэдний шинэ хувилгаан дүрүүдийг тодруулах талаар Монголын бурхан шашинтан, сүсэгтэн олон идэвхийлэн ажиллаж байна. Одоо Энэтхэгийн Гоман дацанд Манзушир хутагтын хойд дүр Д.Цэвээндорж, Ламын гэгээний хойд дүр Б.Эрдэнэбат, Жалханз хутагтын хойд дүр Ч.Данзанчойжинванчиг, Ханчин ринбүчийн хойд дүр Гантөмөр, Гачэн ренбүчийн хойд дүр Ренчинсамбуу, Сариадорж номун ханы хойд дүр С.Даваасүрэн, Дугар Зайсангийн хойд дүр Н.Амгалан нар шавилан сууж, бурхны ном үзэж байгаагаас гадна Дилов хутагтын хойд дүрээр АНУ-д төрсөн халимаг залуу тодорч Данзанламид гэсэн сахилын нэрийг Далай багшаас хүртэн өдгөө Халимагийн нийслэл Элстэй хотноо Алтан хийд хэмээх их хийдийг толгойлон сууж буй. Өнгөрсөн жил жанч халсан IX Богдын хойд дүрийг тодруулах ажил ч шашны дэг жаягаараа нууцлаг байдлаар хийгдэж байгаа. Тэрбээр амьд ахуйдаа “Миний хойд дүр Монголоос тодорно” хэмээн тов тодорхой айлдсан байдаг.

Энэ мэт Монголд хутагт хувилгаад тодруулж ирсэн уламжлал нь угтаа ямар ч цаг үед Монголын төлөө зүтгэх эх оронч лидерүүдийг төрүүлэх монгол түмний зүрх сэтгэлийн далд илэрхийлэл мөн бөгөөд олон түмний хайр хүндэтгэл, итгэл бишрэлийг хүлээсэн, бас ч тусгай нөхцөлд сурч хүмүүжсэн эрдэм чадалтай хөвгүүдийг тэтгэн боловсруулж ирсэн Монгол ухааны ид бах гэлтэй. Монголоо гэх Монгол сэтгэлтэн олноороо төрж, Монгол эх орон цэцэглэн хөгжих нь гарцаагүй биз ээ.

АШИГЛАСАН МЭДЭЭЛИЙН САЙТУУД

1. dharma.mn;
2. mongoliantemple.com;
3. mongolinternet.com;
4. news.mn;
5. zbu.edu.mn;
6. zavkhan.gov.mn;
7. gate1.pmis.gov.mn;
8. numrug.com;
9. olloo.mn;
10. niigmiintoli.mn;
11. kunjajampaling.org;
12. eguzer.blog.gogo.mn;
13. jalkhanz.blogspot.com;
14. nominarhiv.blogspot.com;
15. oronzai.blogspot.com;
16. arimgl.blogspot.com;
17. undestnii-uzel.blogspot.com

РЕЗЮМЕ

В этой статье рассказывается мысль о том, что такие Буддийские понятия как карма, перерождение, бодхисаттва и т.д. приводят верующих к практическому заявлению о перерождении всякого Буддийского религиозного лидера для того, чтобы возвышать его до общественно-политического лидера примером чего являются многие монгольские хубилганы, которые были репрессированы в после победы народной революции в Монголии и в основном в 1930-х годах. В настоящее время монголы перевозвышают хубилганов, что выражает желание монгольского народа передвигать отечественных лидеров.